

СОЁМБО МЭДЭЭ

ЗАСГИЙН ГАЗАР

**ХҮН АМ ЖИЛД
ДУНДЖААР 2.2 ХУВИАР
ӨСЧ БАЙНА**

Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаан 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр боллоо.

Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийг хоёрдугаар улирлаас барьж эхэлнэ

Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-ийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг нь боловсруулан баталгаажуулж, хоёрдугаар улирлаас барьж эхэлнэ. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил нэвтрэх цэг, шилжүүлэн ачих байгууламж барих талаар Хятадын талтай энэ сард харилцан тохиролцох, боомттой холбоотой асуудлыг “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т энэ онд нэмэлтээр тусгахыг холбогдох сайд нарт даалгав.

Протез, ортопедийн болон тусгай хэрэгсэл үйлдвэрлэхийг дэмжинэ

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Дэл Оюу Дөл” компанийн “Эрхэм чанар” протезийн үйлдвэрт тодорхой хэмжээний хөрөнгийг эргэн төлөх нөхцөлтэй олгохоор болов. “Эрхэм чанар” үйлдвэр нь олон улсын жишиг, стандартад нийцсэн протезийн үйлдвэр, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний сувиллын газартай. Өвчин эмгэг, гэмтэл бэртлээс үүссэн үр дагаврыг арилгах, сэргээн засах, хөдөлгөөн сайжруулах, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, протез, ортопедийн хэрэгсэлд дасган сургах зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Сүүлийн гурван жилд 3,000 гаруй хүнийг дээд, доод мөчний бүх төрлийн хиймэл эрхтэн, согог засах гутал, хөл, гарын чиг, таяг, сонсголын аппарат болон бусад туслах хэрэгсэлтэй болгосон байна.

Хүн ам жилд дунджаар 2.2 хувиар өсч байна

2020 оны хүн ам, орон сууцны улсын тооллогын дүн гарлаа. Хүн ам 3 сая 296 мянга 866, өрхийн тоо 897 мянга 427 болжээ. Энэ нь 2010 оны улсын тооллогоос хойш хүн ам жилд дунджаар 2.2 хувиар өссөн гэсэн үг юм. Нийт хүн амын 31.5 хувь нь 0-14, 64.4 хувь нь 15-64, 4.1 хувь нь 65 түүнээс дээш насныхан байна. Хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган иргэн байгаа нь нийт хүн амын 3.3 хувь бол 897.4 мянган өрх 770.9 мянган сууцанд амьдардаг. Суурин хүн амын 87.8 хувь нь гар утастай, 64.7 хувь нь интернэт хэрэглэдэг. Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 9.9 хувьтай байгаа бөгөөд Дорнод аймагт хамгийн өндөр буюу 20.8, Баян-Өлгий аймагт 15.2, Улаанбаатар хотод 14.5 хувьтай гэсэн дүн гарчээ.

Товч мэдээ
-2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр нийслэлд 36 мянга 412, орон нутагт 50 мянга 371 иргэнийг дархлаажуулснаар улсын хэмжээнд нийт 466 мянга 946 хүнийг дархлаажуулалтад хамруулаад байна.

- 2021 оны 4 дүгээр сарын 6-ны байдлаар улсын хэмжээнд 3,794 хүн тусгаарлагдаж байна. Байруудад онцгой байдлын 170, цагдаагийн 201, эрүүл мэндийн 314, нийт 685 алба хаагч, ажилтан ажиллаж байгаа аж.

- Ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд 346.2 тэрбум төгрөгийг 5,129 зээлдэгч, үүнээс 772 аж ахуйн нэгж, 4,357 иргэнд олгоод байна. Монголбанкны урт хугацаат репо санхүүжилттэй зээлийн хүрээнд 216.2 тэрбум төгрөгийг 1,455 зээлдэгч, үүнээс 1,101 аж ахуйн нэгж, 354 иргэнд олгосон. 2,547 зээлдэгч 190.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авчээ.

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ДЭГ ЖУРАМ,
САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААН БОЛЛОО**



Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн өргөтгөсөн хоёрдугаар хуралдаан өчигдөр боллоо. Тус хуралдаанд БХЯ-ны газрын дарга нар, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, ҮБХИС-ийн удирдлагууд оролцсон бөгөөд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хуралдааныг удирдан явуулсан юм. Хуралдааны эхэнд Батлан хамгаалахын сайдын баталсан 4 дүгээр сарын 2-ны өдрийн удирдамжийн дагуу Улаанбаатар цэргийн хүрээний, тэр тусмаа хугацаат цэргийн алба хаагчидтай ангиудад ажилласан талаарх тайлантай танилцав. Тодруулбал, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа С.Ганбямба, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр нараар ахлуулсан ажлын дөрвөн хэсэг энэ сарын 2-5-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 013, 014, 015, 017, 029, 119, 120, 311, 326 дугаар ангиудын хугацаат цэргийн алба хаагчидтай уулзалт зохион байгуулж, тэдний алба хааж буй орчин нөхцөлтэй танилцан санал сэтгэгдлийг нь сонссоноос гадна тэднээс судалгаа авчээ. Судалгаанд 800 гаруй хугацаат цэргийн алба хаагч хамрагдсан бөгөөд 97-оос дээш хувь нь удирдах дарга нар цэргийн албаны дүрмийн дагуу ёс зүйтэй харьцдаг, ямар нэгэн дарамт шахалт байдаггүй, албандаа сэтгэл хангалуун байна гэсэн дүгнэлт өгснийг хурандаа Ж.Болдбаатар онцлолоо.

Түүнчлэн аливаа хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад сэтгэл зүйн болон хуулийн

баг ажиллуулах, “Иргэний зөвлөл” байгуулах тухай хэлэлцэж, ойрын хугацаанд дээрх чиглэлүүдээр ажиллах журам боловсруулан ажлуудыг эхлүүлэх шийдэлд хүрлээ.

Хурлын төгсгөлд Батлан хамгаалахын дэд сайд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн дарга Б.Баярмагнай ЗХЖШ, төрлийн цэргийн командлалууд, нэгтгэл, анги, байгууллагын сахилга, дэг журмын байдалд бодит судалгаа, дүн шинжилгээ хийж, хүний эрхийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, холбогдох байгууллагуудын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлж, Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам, дэглэмийг чанд мөрдөх, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын алба, яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ үнэлгээний газартай хамтран хугацаат цэргийн алба хаагчидтай анги, салбаруудын цэргийн албаны зохион байгуулалт, хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, дүнг танилцуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тодотгол хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг чангатгах ажлын нэмэлт төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, хугацаат цэргийн алба хаагчидтай явуулах соёл хүмүүжлийн ажлын чанар, үр нөлөөг сайжруулах, сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан, ажлын хариуцлага алдсан алба хаагчдад тухай бүр нь арга хэмжээ авч, архидаан согтуурсан, харьцааны зөрчил гаргасан албан хаагчийг ажлаас нь чөлөөлөх хүртэл хариуцлага тооцож, бүх шатны дарга, захирагч нарын сахилга хариуцлагыг өндөржүүлэх үүрэг чиглэлүүдийг өглөө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
Өдөр	Шөнө
+13	-3
ӨМНӨД СУДАН	
Өдөр	Шөнө
+38	+24
АФГАНИСТАН	
Өдөр	Шөнө
+17	+4

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.00	2,856.00
EUR	3,356.00	3,415.00
CNY	433.70	437.10
RUB	36.50	38.00
JPY	25.65	26.14
KRW	2.46	2.60

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 27
2021.04.08.
/ПҮРЭВ ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД
ЦАГААЧИН ТУУЛАЙ
САРЫН ЕСӨН УЛААН УЛААН
НОХОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

Наран ургах, шингэх:

06.16-19.32

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал:

Төмөр.

Аргын тооллын 4 сарын 8, Бархасвадь гараг. Билгийн тооллын 27, Чөдөр одтой, улаан нохой өдөр. Өдрийн наран 6 цаг 16 минутад мандан, 19 32 минутад жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хишиг далага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, эрдэнийг гадагш өгөх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсоод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН 575	НИЙТ БҮРТГЭГДСЭН 12226	ЭДГЭРСЭН 6912	НАС БАРСАН 25
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНӨЛӨГ	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ	ЭДГЭРСЭН	НИЙТ БАТЛАГДСАН
ШИНЭЭР НЭМЭГДСЭН 14	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 277	ЭДГЭРСЭН 1276	НИЙТ БАТЛАГДСАН 1559

МУ-ын хэмжээнд 04 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар нийт 536301 (25.6%) иргэн КОВИД-19 эсрэг вакцины эхний тунд хамрагдлаа.

Нийслэлд нийт 451626 (39.0%) иргэн Орон нутагт нийт 84681 иргэн

ҮЙЛ ЯВДАЛ

“АРАВТ-2021”, “ЦЭРГИЙН РАЛЛИ-2021” УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАЖ ЭХЭЛЛЭЭ



ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Олон улсын цэргийн наадам-2021” цогцолбор тэмцээний “Аравт-2021” олон улсын морин цэргийн уралдаан, “Цэргийн ралли” цэргийн авто машины уралдааны нэгдүгээр үе шатыг энэ жил Монгол Улсын Зэвсэгт хүчин өөрийн нутаг дэвсгэрт зохион байгуулна. Монгол Улсын Зэвсэгт хүчин “Олон улсын цэргийн наадам”-д 2019 онд оролцогчоос зохион байгуулагч орны статустайгаар оролцож, “Аравт-2019” морин цэргийн олон улсын уралдааныг өөрийн нутагт зохин байгуулснаар дэлхийн орнуудаас томоохон үнэлгээ авч чадсан юм.

“Аравт-2021”, “Цэргийн ралли-2021” уралдааныг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг

хангах Ажлын хэсгийн хурал 4 дүгээр сарын 6-ны өдөр боллоо. Ажлын хэсгийг Монгол Улсын талаас “Олон улсын цэргийн наадам”-ыг зохион байгуулах хорооны дарга, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг удирдан явуулж, тодорхой үүрэг, чиглэлүүдийг өгсөн юм. “Аравт-2021” уралдааныг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийг түшиглэн явуулахтай холбоотой бэлтгэл ажлыг бүрэн хангах, “Цэргийн ралли-2021” уралдааныг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, “Аравт-2021” морин цэргийн олон улсын уралдааныг өөрийн нутагт зохин байгуулснаар дэлхийн орнуудаас томоохон үнэлгээ авч чадсан юм.

“Аравт-2021”, “Цэргийн ралли-2021” уралдааныг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг

ЦАХИМ ШУУДАНД

ШҮХЭРЧИН ДАЙЧИД 620 УДААГИЙН БУУЛТЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ

Зэвсэгт хүчний 084 дүгээр анги

Ангийн 2020-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 2021 оны эхний шүхрийн дадлага, буултыг энэ сарын 3-6-ны өдрүүдэд Төв аймгийн нутаг дэвсгэрт амжилттай хийлээ.

Байгаль, цаг агаарын зөвшөөрөгдсөн нөхцөлд ямар ч газар оронд нисдэг тэрэгнээс шүхрээр буух дадлага нь танилцах буулт, шүхрийн дэлбээг удирдлагын оосрын тусламжтай эргүүлэх, ачаа, зэвсэгтэй шүхрийн буулт зэрэг дасгалуудаар явагдаж, алба хаагчдынхаа ур чадварыг нэмэгдүүлж чадсан юм. Мөн далавч хэлбэрийн шүхрээр буух, шүхэрчин спорт гараагаар бүтэн болон хагас албадан гар аргаар шүхрийг задлах, агаарт удирдлага хийх, газрын салхины чиглэлийг тогтоох, цэг онолтын дасгалуудыг боловсрууллаа. Энэ удаагийн нислэг, буултад давхардсан тоогоор 10 цагийн нислэг, 620 удаагийн буултыг амжилттай хийж гүйцэтгэв. Мөн 20 гаруй цэргийн алба хаагч анхны буултаа хийсэн бөгөөд Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Гансэлэм буултын явцтай танилцсан юм.

Ахмад В.БАЯРСАЙХАН



КОВИДГҮЙ МАРГААШИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Монгол Улсын хэмжээнд “Covid-19” цар тахлын халдварын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж хөдөө орон нутгаар тархаад байгаа энэ цаг үед Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн удирдлага, хамт олон “Ковидгүй маргаашийн төлөө хамтдаа” уриан дор ангийн харьяа тусгай салбаруудаараа дамжуулан “Mask” аяныг өрнүүлээд байна.

Аяны хүрээнд Завхан, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын сум орон нутгийн ард иргэдэд нийт 10000 ширхэг маскийг тарааж, цар тахлаас урьдчилан сэргийлэхэд хүн бүрийн идэвх, санаачилга, оролцоо чухал гэдгийг уриалан, маскаа тогтмол зүүж байхыг санууллаа.

Ахмад Н.МӨНХБААТАР

ТӨЛӨВЛӨГӨӨТ СУРГАЛТ, ДАДЛАГА ЯВУУЛАВ

Зэвсэгт хүчний 150 дугаар анги

Ангийн 2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу үндсэн салбарын жигдрэлтийг хангах шатны хээрийн гаралт, полигоны дадлагын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, 3 дугаар сарын 19-ний өдрөөс 4 дүгээр сарын 9-ний өдрийг хүртэл, 21 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн районд амжилттай зохион байгууллаа.

Хээрийн гаралтын төлөвлөлт, хичээлийн хуваарийн дагуу тусгай бэлтгэл, сэтгэл зүйн бэлтгэл, ҮОХЗХБ, холбооны бэлтгэл, инженерийн бэлтгэл, галын бэлтгэл хичээлийн буудлагын дасгалууд, биеийн тамирын бэлтгэл хичээлүүдийг өдрийн 10 цагаар төлөвлөн явууллаа. Тасаг, тоотын буудлагыг салаа, салбарын захирагч нар удирдан зохион байгуулж, салааны байлдааны буудлагатай хоногийн сургуулийг энэ сарын 1-3-ны өдрүүдэд “Тактикийн бүлэгт томилогдсон мотобуудлагын салаа түйвээх байлдааныг зохион байгуулж явуулах”, “Мотобуудлагын салаа отолт бэлтгэж явуулах”, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа давшилтад /хот дотор/ сэдвүүдээр зохион байгуулж явуулсан нь энэ удаагийн хээрийн гаралтын онцлогтой байлаа. Төлөвлөгөөний дагуу ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот тал, хээрийн нөхцөлд зах нийлсэн байдлаас давших байлдааныг зохион байгуулах” сэдвээр тус тус явуулав.

Ахмад Н.АМАРБАЯСГАЛАН



СУРГАЛТ ДАДЛАГА

ЦАХИМ БУЮУ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЦЭРГИЙН СУРГАЛТ


Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлд цахим сургалт, технологид суурилсан сургалтыг нэвтрүүлэх ажлыг ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсээс үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Та бүхэнд цахим сургалт буюу технологид суурилсан сургалтын талаар тодорхой ойлголтыг өгье.

Цахим сургалт гэж юу вэ?

Эрдэмтэн Л.Моори, Криста Галиен нар “Хичээл заахдаа 20 хувьд нь технологи ашиглаж байвал энэ хичээлийг цахим хичээл буюу цахим сургалт” гэж тодорхойлсон. Цахим сургалтын томъёолол нь компьютерт суурилсан сургалт, сайтад суурилсан сургалт, виртуал сургалт, телевиз, радиогийн сургалт зэргийг агуулах сургалтын нэгэн хэлбэр бөгөөд энэ нь суралцагчдад үзүүлэх үйлчилгээний өргөн цар хүрээг агуулсан байдаг.

Цахим сургалт нь суралцагчдад сургалтын агуулгаа хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмж, түүний дотор интернет, хиймэл дагуулийн систем, аудио, видео систем зэргийг ашигладаг ба зайлшгүй ямар нэгэн системээр дамжуулан явуулдаг. Өнөөдөр Зэвсэгт хүчинд орон зай, цаг хугацаанаас үл хамааран цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулах боломж бүхий цахим сургалтын системийг бий болгох нь нэн тэрүүнд авч хэрэгжүүлэх ажил юм. Уг систем нь дараах элементүүдээс бүрдэнэ.

1.Мобайл аппликейшн



Цахим сургалтын системтэй холбогдож ажилладаг апплекэйшн нь суралцагчид өөрсдийн мобайл төхөөрөмжийг ашиглан онлайнээр суралцах боломжийг олгодог.

Энэхүү аппликейшнийг ашиглан:

- Цахим сургалтын системд бүртгүүлэх, нэвтрэх;


- Хичээлийн сэдвийг үзэх, зарим контентийг интернетгүй үед үзэх боломжтой байх;
- Хүссэн мэдээлэл, хичээлээ хайх, бусад хэрэглэгчидтэй харилцах;
- Мобайл төхөөрөмжөөс файл байршуулах, хадгалах;
- Өөрт шаардлагатай нэмэлт олон боломжийг ашиглах.

2.Цахим хурлын өрөө



Цахим хурлын өрөө нь гадаад харилцаа болон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын хоорондын харилцааг дэмжих, орон зайнаас үл хамааран цахим сургалт, уулзалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад зориулагдсан орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

3.Мултимедиа танхим



Мултимедиа танхим нь цахим хичээлийг дуу болон дүрс бичлэгийн өндөр чанартай бэлтгэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг. Энд цахим хичээл бэлтгэхээс гадна Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах видео, аудио бичлэгүүд болон байлдааны зэвсэглэл, техникийн видео танилцуулга зэргийг үзүүлэх боломжтой юм. Цахим сургалтын үр дүн, чанар нь зөвхөн хэрэглэгдэхүүний шинж чанараас шалтгаалахгүй бөгөөд суралцагчийн цахим сургалтад бэлэн эсэх, багшийн заах арга зүй, технологийн мэдлэгийн хүчин зүйлийн нэгдлээр илэрхийлэгдэнэ.

Дэд хурандаа А.БАТСҮХ

“СОЁМБО” СОНИНЫ ӨНӨӨДРИЙН ДУГААРТ

Эрхэм уншигч Та Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний “Соёмбо” редакцияас долоо хоног тутам эрхлэн гаргадаг “Соёмбо” сонины 14 дэх дугаар хэвлэгдлээ. Та УИХ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд асан Н.Энхболдын “Монгол цэрэг хэмээх их айлын бодлогыг тодорхойлолцож явсан минь миний удмын бахархан дурсах өв билээ” ярилцлагыг уншаарай. Мөн ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Орон сууцны хэлтсийн дарга, хурандаа Ц.Ганбатаас удахгүй Зэвсэгт хүчний барилга, байгууламжид мөрдөгдөж эхлэх шинэ стандартын талаарх мэдээллийг тодруулсан бөгөөд “Зүүдэн бороо”, “Хар нүдэн бүсгүй” зэрэг Монголын ард түмний сэтгэлд хоногшсон дуунуудыг зохиосон УГЗ Б.Магсаржавын “Цэргийн чуулга намайг алдаршуулсан”, ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн коллежийн багш, доктор (Ph.D), дэд профессор Ш.Цогтгэрэлийн “ҮБХИС цэргийн мэргэжлийн дипломтой боловсон хүчнийг 1991 оноос бэлтгэж эхэлсэн” ярилцлагуудыг хүргэж байна. Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэнд “амилсан” цэргийн сэдэвт шилдэг бүтээлүүдийн талаар болон дэлхийн цэргийн хөгжмийн түүхэн замнал, Аугаа их Эх орны дайны үеийн хамгийн алдартай 5 дуу зэрэг сонирхолтой мэдээлүүдийг танд зориулан бэлтгэлээ.

Монгол Улсын төлөө зүтгэл! БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

СОЁМБО

Монгол Улсын 2010, 2015, 2016 оны салбарын шилдэг сонин | 2021.04.08 №14 (1874) | Үнэ 600 төгрөг

Дугаарын зочин: Б.Магсаржав ЦЭРГИЙН ЧУУЛГА НАМАЙГ АЛДАРШУУЛСАН

УИХ-ЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД АСАН Н.ЭНХБОЛД

МОНГОЛ ЦЭРЭГ ХЭМЭЭХ АЙЛЫН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОЛЦОЖ ЯВСАН МИНЬ МИНИЙ УДМЫН БАХАРХАН ДУРСАХ ӨВ БИЛЭЭ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018

И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn

Утас: 70001029